



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/542

Есөнбулаг

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх  
намрын дархлаажуулалтын ажлыг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27<sup>1</sup> дугаар зүйлийн 27<sup>1.2</sup> дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.10 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/251 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 15 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад орон нутгийн төр захиргааны байгууллагууд, малчид мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийг татан оролцуулж, ажиллах хүч, хашаа хороо, тээврийн хэрэгсэл бусад шаардлагатай асуудлыг шуурхай шийдвэрлэж, тогтоосон хугацаанд зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Вакцин биобэлдмэл, халдвар хамгааллын хувцас, халдваргүйтгэлийн бодисыг хугацаанд нь татан авч хуваарилах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үр дүнг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР